

**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20 ДУГААР ХОРООНЫ
НУТАГТ БАЙРЛАХ “ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ,
ИМПОРТ, ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ: ИМПЕРИАЛ ПАРТНЕРС ХХК

2023 он

АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА -----	2
1.1. Тухайн жилийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн товч танилцуулга -----	2
1.2. Төслийн дэд бүтэц -----	2
1.3. Хог хаягдал -----	3
1.4. Химийн бодисын агуулах -----	5
1.5. Төслийн хүрээнд ашиглагдах химийн бодис -----	6
ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ -----	10
2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах -----	10
2.2. Усны зохистой хэрэглээ ба нөөц баялгийг хамгаалах -----	10
2.3. Хөрс, ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арилгах, арга хэмжээ	
2.4. Орчны тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөгөөний биелэлт -----	10
2.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт -----	10
ГУРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ -----	11
3.1. Агаарын чанарын хяналт шинжилгээ -----	11
3.1.1. Агаарын чанарын шинжилгээг гүйцэтгэх арга зүй -----	11
3.2. Хөрсний чанарын хяналт шинжилгээ -----	14
ДӨРӨВ. БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ -----	16

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил.....	2
Зураг 2. Агуулахын хашаан дотор авто машин зорчих хэсэг.....	4
Зураг 3. Химийн бодис хадгалах агуулах, 6-н тусгаарлах хэсэг.....	4
Зураг 4. Агуулахын дотоод орчин.....	5
Зураг 4. Агаар дахь хүхэрлэг хийн агууламж.....	12
Зураг 5. Агаар дахь азотын давхар ислийн агууламж.....	13
Зураг 6. Агаар дахь нийт тоосонцрын агууламж.....	13
Зураг 7. Дуу шуугианы норм.....	14
Зураг 8. Хөрсний дээж.....	15
Зураг 9. Хар тугалга, зэсийн агууламж.....	15
Зураг 10. Зэс, цайрын агууламж.....	15

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ


Хүснэгт 1. Ашиглагдах химийн бодисын жагсаалт.....	6
Хүснэгт 2. Агаарын чанарын шинжилгээний дүн.....	12
Хүснэгт 3. Хөрсний чанарын шинжилгээний дүн.....	14
Хүснэгт 4. Дээж авсан цэг.....	15

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Тухайн жилийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн товч танилцуулга

Тус компани нь өнгөрсөн 2023 онд төлөвлөсөн нийт ажлаа 100% гүйцэтгэн, аж ахуйн нэгж, байгууллаг а, харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад нийцүүлэн БНХАУ-ын баталгаат үйлдвэрт үйлдвэрлэсэн стандартын шаардлага хангасан сав баглаа боодолтой, битүүмжлэлтэй бодис нэгдлүүдийг импортлон оруулж, химийн бодисын MNS 6458:2014 стандартын шаардлага хангасан агуулахад хадгалан захиалагчид нийлүүлэн ажиллалаа.

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил



1.2. Төслийн дэд бүтэц

Цахилгаан эрчим хүч: Цахилгаан эрчим хүчийг Улаанбаатар хотын цахилгааны нэгдсэн шугам сүлжээнээс авдаг.

Ус хангамж: Цэвэр, бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон.

Дулаан хангамж: Улаанбаатар хотын төвлөрсөн дулааны системд холбогдсон байна.

1.3. Хог хаягдал

Ахуйн гаралтай хатуу хог хаягдал: “Империа Партнерс” ХХК-ийн нийт ажилчид 8 хүн, улирлын чанартай 5 хүн нэмж ажиллууладаг бөгөөд сар, улирлын ажлын ачааллаар хүний нөөцийг нэмэлтээр төлөвлөдөг бөгөөд хоногт 1 ажилчин дунджаар 0.3 кг хатуу хог хаягдал гаргахаар тооцов.

Нэг өдөрт: Нийт $8 \text{ хүн} \cdot 0.3 \text{ кг} = 2.4 \text{ кг}$, сард буюу 30 хоногт 72 кг, жилд буюу 264 хоногт 648 кг хатуу хог хаягдал гаргахаар байна.

Ажиллагсдын ахуйн хэрэглээнээс гарах хуурай хатуу хог хаягдал (хоолны үлдэгдэл, цаас, хайрцаг, сав баглаа боодол) хүмүүсийн эдэлж хэрэглэж байсан зүйлс багтана. Ахуйн хэрэглээнээс гарах хатуу хог хаягдлыг өөрийн хогийн битүү саванд хуримтлуулан хадгалах ба хуримтлагдсан хогийг сар бүр Баянгол дүүргийн тохижилт үйлчилгээний компанитай байгуулсан гэрээний дагуу ачуулдаг.

Хийн хаягдал нь химийн бодисуудыг агуулахад буулгах болон химийн бодисуудын хадгалалт, агуулахын дотоод орчны нөхцөл болон химийн бодисуудын хадгалалтын горим зөрчигдөх, агуулахын орчны температурын нөлөө, хүний буруутай үйл ажиллагаанаас болж агуулахад бодис исэлдэх, уурших, асгаралт үүсэх, сав баглаа боодлын битүүмжлэл алдагдах зэргээс үүдэлтэй хийн хаягдлын ууршилт үүсэж болзошгүй.

Агуулахаас үүсэх аюултай хог хаягдал: Химийн бодисуудыг импортлон захиалагчдад нийлүүлэх хүртэл хадгалах хугацаанд үүссэн аюултай хог хаягдлыг агуулахаас үүсэх хаягдал гэж үзнэ. Үүнд:

- a. Химийн бодисыг ачиж, буулгах үед гарах цэвэрлэгээ, ариутгал, жийргэвчид хэрэглэсэн цаас, даавуу, бээлий зэрэг байх ба магадгүй асгаралт үүсэх үед гарсан тостой шороо, элс, үнс зэрэг үлдэгдлүүд
- b. Санамсар болгоомжгүйгээс үүссэн асгарч алдагдсан бодисын үлдэгдэл, гэмтсэн сав баглаа боодол бусад үлдэгдлүүд

Дээрх хаягдлуудыг агуулахын хашаанд тохижуулан бэлтгэсэн битүүмжлэлтэй аюултай хог хаягдлын цэгт эх үүсвэр дээр нь 180 хоног хадгална. Дараа нь аюултай хог хаягдлыг тогтсон хугацаанд “Цэцүүх трейд” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу хог хаягдлыг зайлуулна.



Зураг 2. Агуулахын хашаан дотор авто машин зорчих хэсэг



Зураг 3. Химийн бодис хадгалах агуулах, 6-н тусгаарлах хэсэг

Төсөл хэрэгжих агуулахын байршил нь Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дахь үйлдвэрийн бүсэд байрлах бөгөөд ДЦС-4-ийн баруун хойно, толгойт өртөөний салаа төмөр замын агуулахын байрнаас 500 метр зайд байрладаг.

1.4. Химийн бодисын агуулах

Тус төсөлд ашиглах химийн бодисын агуулах нь МХЕГ-ын MNS 6458:2014 стандартын шаардлага хангасан дүгнэлттэй, нийт 500м² талбайтай, цэвэр бохир ус, дулаан нь төвийн шугамд холбогдсон, механик агааржуулалттай, зохиомол гэрэлтүүлэгтэй, хана, шал нь химийн бодисоос үүссэн тоос, уур, манан тогтохооргүй материалаар хийгдсэн, 320-350 люкс гэрэлтүүлэгтэй, агуулахад байвал зохих дохио үг, анхааруулах тэмдэглэгээ болон галын аюулын үед хэрэглэх галын сараа, хэрэгсэлтэй, бодис, нэгдлүүдтэй харьцан ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа, зөвлөмжүүдийг байршуулсан байна. Агуулах нь гадаад орчноос бетон хашаагаар тусгаарлагдсан, ажилчдаас өөр хүн нэвтрэх боломжгүй, харуулын байртай, гадаад талбай нь бетонон бүрэн цутгамал зэргийг дурьдаж болно. Агуулахын гадаад болон дотоод нөхцлийг дараах зургуудаар баталгаажуулав.



Зураг 4. Агуулахын дотоод орчин

1.5. Төслийн хүрээнд ашиглагдах химийн бодис

Империал Партнерс ХХК нь жилд нийтдээ 109 нэр төрлийн 63,260.0 тн химийн бодис нэгдлүүдийг импортлон, хадгалж, худалдаалахаар төлөвлөж байгаа бөгөөд нэр төрөл, тоо хэмжээ, олон улсын дугаар болон бусад мэдээллийг дараах хүснэгтээр үзүүлээ.

Хүснэгт 1. Ашиглагдах химийн бодисын жагсаалт

№	Химийн нэршил, томъёо	Томъёо	Олон улсын нэршил,	CAS	Хэмжээ
1.	Азотын хүчил	HNO ₃	Nitric acid	7697-37-2	1000тн
2.	Этанол	C ₂ H ₅ OH	Ethanol	64-17-5	500тн
3.	Этиленгликоль	C ₂ H ₆ O ₂	Ethylene glycol	107-21-1	200тн
4.	Шоргоолжний хүчил	HCOOH	Formic acid	64-18-6	100тн
5.	Натрийн карбонат	Na ₂ CO ₃	Sodium carbonate	497-19-8	2000тн
6.	Натрийн нитрит	NaNO ₂	Sodium nitrite	7632-00-0	1000тн
7.	Тринатри фосфат	Na ₃ PO ₄ *12H ₂ O	Trisodium phosphate	10101-89-0	300тн
8.	Кальцийн хлорид	CaCl ₂	Calcium chloride	10043-52-4	500тн
9.	Кальцын гидроксид	Ca(OH) ₂	Calcium hydroxide	1305-62-0	500тн
10.	Кальцийн гипохлорат	CaO ₂ Cl ₂	Calcium hypochlorite	7778-54-3	500тн
11.	Кальцийн оксид	CaO	Calcium oxide	1305-78-8	500тн
12.	Метилийн спирт	CH ₃ OH	Methanol	67-56-1	100тн
13.	Тосны хүчил	C ₁₈ H ₃₄ O ₂	Oleic acid	112-80-1	100тн
14.	Натрийн силикат	Na ₂ SiO ₃	Sodium metasilicate	6834-92-0	100 тн
15.	Натрийн хлорид	NaCl	Sodium chloride	7647-14-5	1000тн
16.	Шингэн хлор	Cl ₂	Chlorine	7782-50-5	300тн
17.	Ацетон	CH ₃ COCH ₃	Acetone	67-64-1	5тн
18.	Зэсийн сульфат	CuSO ₄ *5H ₂ O	Copper sulfate	7758-99-8	100тн
19.	Магнийн хлорид	MgCl ₂ n	Magnesium chloride	7786-30-3	500тн
20.	Аммиак	NH ₄ OH	Ammonia	1336-21-6	400тн
21.	Борын хүчил	H ₃ BO ₄	Boric acid	10043-35-3	200тн
22.	Глицерин	C ₃ H ₈ O ₃	Glycerol	56-81-5	100тн
23.	Калийн карбонат	K ₂ CO ₃	Potassium carbonate	584-08-7	100тн
24.	Калийн иод	KJ	Potassium Iodide	7681-11-0	200тн
25.	Лимоны хүчил	C ₆ H ₈ O ₇ *H ₂ O	Citric acid	5949-29-1	100тн
26.	Хөнгөнцагааны хлорид	AlCl ₃	Aluminum chloride	7446-70-0	500тн
27.	Карбид калыц	CaC ₂	Calcium carbide	ГОСТ 1460-81 Cas 75-20-7	500тн
28.	Калийн гидроксид	KOH	Potassium hydroxide	1310-58-3	300тн
29.	Натрийн сульфит	Na ₂ SO ₃	Sodium sulfite	7757-83-7	50тн
30.	Бор хүчлийн натри	Na ₂ B ₄ O ₇ *10H ₂ O	Sodium tetra borat	1303-96-4	100тн
31.	Калийн нитрат	KNO ₃	Potassium nitrate	7757-79-1	50тн
32.	Хлорформ	CH ₃ Cl	Chloroform	67-66-3	1тн

33.	Натрийн триполифосфат	$\text{Na}_5\text{P}_3\text{O}_{10}$	Sodium tripolyphosphate	7758-29-4	100тн
34.	Калийн бромид	KBr	Potassium bromide	7758-02-3	50тн
35.	Цайрын хлорид	ZnCl_2	Zinc chloride	7646-85-7	500тн
36.	Бензойны хүчил	$\text{C}_7\text{H}_6\text{O}_2$	Benzoic acid	65-85-0	50тн
37.	Мочевин	$\text{CH}_4\text{N}_2\text{O}$	Urea	57-13-6	100тн
38.	Цууны хүчил	CH_3COOH	Acetic acid	64-19-7	100тн
39.	Лантоны оксид	La_2O_3	Lanthanum oxide	1312-81-8	20тн
40.	Антрацит	$\text{C}_{15}\text{H}_{11}\text{O}$	Coal antracite	8029-10-5	500тн
41.	Тиокарбамид Тиомочевин, Тиоуреа	$(\text{NH}_2)_2\text{CS}$	Thiourea	CAS : 62-56-6 ГОСТ 6344-73	50тн
42.	Гидразин гидрат	$\text{NH}_2\text{NH}_2 \cdot \text{H}_2\text{O}$	Hydrazine Hydrate	10217-52-4 7803-57-8	1500тн
43.	Натрийн гипохлорид	NaClO	Sodium hypochlorite	7681-52-9	500тн
44.	Мөнгөний нитрат	AgNO_3	Silver nitrate	7761-88-8	1тн
45.	Аскорбиний хүчил	$\text{C}_6\text{H}_8\text{O}_6$	L-Ascorbic acid, Vitamin C	50-81-7	5тн
46.	Бензол	C_6H_6	Benzene, Phenyl hydride,	71-43-2	50тн
47.	Калийн перманганат	KMnO_4	Potassium permanganate	7722-64-7	5тн
48.	Цууны хүчлийн ангидрид	$(\text{CH}_3\text{CO})_2\text{O}$	Acetic anhydride	108-24-7	1тн
49.	Калийн дихромат	$\text{K}_2\text{Cr}_2\text{O}_7$	Potassium dichromate	7778-50-9	5тн
50.	Фосфорын хүчил	H_3PO_4	Phosphoric acid	7664-38-2	100тн
51.	Ванилин	$\text{C}_8\text{H}_8\text{O}_3$	Vanillin	121-33-5	50тн
52.	Цардуул	$(\text{C}_6\text{H}_{10}\text{O}_5)_n$	Starch	9005-84-9	5тн
53.	Несслерийн Урвалж	$\text{K}_2(\text{HgI}_4)$	Nessler reagent	7783-33-7	5тн
54.	Сегнетийн давс	$\text{KNaC}_4\text{H}_4\text{O}_6 \cdot 4\text{H}_2\text{O}$	Potassium sodium tartrate	6381-59-5	5тн
55.	Ди этилийн эфир	C_4H_{10}	Diethyl ether	60-29-7	50тн
56.	Натрийн гидроксид	NaOH	Sodium hydroxide	1310-73-2	2000тн
57.	Давсны хүчил	HCl	Hydrochloric acid	7647-01-0	5000тн
58.	Хүхрийн хүчил	H_2SO_4	Sulfuric acid	7664-93-9	10000тн
59.	Гептан	C_6H_{14}	Heptane	142-82-5	50тн
60.	Натрийн сульфид	Na_2S	Sodium sulfide	1313-82-2	100тн
61.	Полиакриламид /РАМ/	$(\text{C}_3\text{H}_5\text{NO})_n$	Polyacrylamide	9003-05-8	500тн
62.	Поли хөнгөнцагааны хлорид /РАС/	$\text{AlnCl}(3m-n)(\text{OH})_m$	Poly Aluminium chloride	1327-41-9	400тн
63.	Пропилен гликоль	$\text{C}_3\text{H}_8\text{O}_2$	Propylene glycol	57-55-6	50тн

64.	Азот хүчлийн кальци	$\text{Ca}(\text{NO}_3)_2 \cdot 4\text{H}_2\text{O}$	Calcium nitrate	10124-37-5	50тн
65.	Азот хүчлийн цайр	$\text{Zn}(\text{NO}_3)_2 \cdot 6\text{H}_2\text{O}$	Zinc nitrate hexahydrate	10196-18-6	5тн
66.	Аммоний бифторид	NH_4HF_2	Ammonium hydrogen difluoride	1341-49-7	50тн
67.	Натрийн гексаметафосфат	$\text{Na}_6\text{P}_6\text{O}_{18}$	Sodium hexametaphosphate	10124-56-8	5тн
68.	Глауберийн давс	$\text{Na}_2\text{SO}_4 \cdot 10\text{H}_2\text{O}$	Glauber's salt	7727-73-3	100тн
69.	Натрийн тиосульфат	$\text{Na}_2\text{S}_2\text{O}_3$	Sodium thiosulfate	7772-98-7	5тн
70.	Натрийн хэт исэл	Na_2O_2	Sodium peroxide	1313-60-6	50тн
71.	Устөрөгчийн хэт исэл	H_2O_2	Hydrogen peroxide	7722-84-1	500тн
72.	Формалин	HCHO	Formaldehyde	50-00-0	50тн
73.	Хартугалганы оксид	PbO	Lead oxide	1317-36-8	200тн
74.	Хөнгөнцагааны исэл	Al_2O_3	Aluminum oxide	1344-28-1	50тн
75.	Хүнсний сод	NaHCO_3	Sodium carbonate	144-55-8	100тн
76.	Цуу хүчлийн натри	$\text{C}_2\text{H}_3\text{NaO}_2$	Sodium acetate	127-09-3	5тн
77.	Сульфамины хүчил	$\text{NH}_2\text{SO}_3\text{H}$	Sulfamic acid	5329-14-6	100тн
78.	Полипентантетрфта лат	$(\text{C}_{10}\text{H}_8\text{O}_4)_n$	Polyethylene terephthalate	25038-59-9	500тн
79.	Бромын хүчил	HBr	Hydrogen bromide	10035-10-6	50тн
80.	Бутилийн спирт	$\text{C}_4\text{H}_9\text{OH}$	Butanol	71-36-3	50тн
81.	Гексан	$\text{CH}_3(\text{CH}_2)\text{CH}_3$	Hexan	110-54-3	5тн
82.	Глюкоз	$\text{C}_6\text{H}_{12}\text{O}_6$	Glucose	59-23-4	50тн
83.	Пиридин	$\text{C}_5\text{H}_5\text{N}$	Pyridine	110-86-1	50тн
84.	Сульфанилийн хүчил	$4\text{-NH}_2\text{C}_6\text{H}_4\text{-SO}_3\text{H}$	Sulfanilic acid	121-57-3	50тн
85.	Аммони	NH_3	Ammonia	7664-41-7	20тн
86.	Фторт натри	NaF	Sodium fluoride	7681-49-4	50тн
87.	Хурган чихний хүчил	$\text{C}_2\text{H}_2\text{O}_4$	Oxalic acid dihydrate	144-62-7	200тн
88.	Виннийн хүчил	$\text{C}_4\text{H}_6\text{O}_6$	Tartaric acid	526-83-0	5тн
89.	Стеарины хүчил	$\text{C}_{18}\text{H}_{36}\text{O}_2$	Stearic Acid	57-11-4	50тн
90.	Дифенил карбазон	$\text{C}_{13}\text{H}_{12}\text{N}_4\text{O}$	2-benzylcyclohexanone	946-33-8	50тн
91.	Молибден хүчлийн аммони	$(\text{NH}_4)_6\text{Mo}_7\text{O}_{24} \cdot \text{H}_2\text{O}$	Ammonium molybdate	12054-85-2	50тн
92.	Сахароз	$\text{C}_{12}\text{H}_{22}\text{O}_{11}$	Sacharose	57-50-1	50тн
93.	Толуол	$\text{C}_6\text{H}_5\text{CH}_3$	Toluene	108-88-3	50тн
94.	Трилон – Б	$\text{C}_{10}\text{H}_{14}\text{N}_2\text{-Na}_2\text{O}_8 \cdot \text{H}_2\text{O}$	Disodium salt, dihydrate	6281-92-6	2тн
95.	Фторт устөрөгч	HF	Hydrofluoric acid	7664-39-3	200тн
96.	Диизобутилнатри Дитиофосминат	$\text{C}_8\text{H}_{18}\text{NaO}_2\text{PS}$	Sodium diisobutyl dithiophosphinate	53378-51-1	1000тн

97.	Калийн Амил Ксантат	$C_6H_{11}KOS_2$	Potassium Amyl Xanthate	2720-73-2	1500тн
98.	Метил Изобутил Карбинол	$C_6H_{14}O,$ $(CH_3)_2CHCH_2CH(OH)CH_3$	Methyl isobutyl carbinol MIBC	108-11-2	10000тн
99.	Изопропил этил динокарбамат	$C_6H_{13}NOS$	Isopropyl ethyl thionocarbamat IPETC	141-98-0	10000тн
100.	Натрийн Изобутил Ксантат	$C_5H_9NaOS_2$	Sodium Isobutyl Xanthate	25306-75-6	1000тн
101.	Магнийн исэл mgo	MgO	Magnesium oxide	1309-48-4	100тн
102.	Натрийн гидросульфит	$NaHSO_3$	Sodium bisulfite	7631-90-5	100тн
103.	Нунтаг магнезит	Dalpor P88		Гост 24717	300тн
104.	Сульфат марганцийн давс	$MnSO_4 \cdot H_2O$		10034-96-5	1000тн
105.	Анионы шүүгч	-	AB-17-8	Гост 20298-74	100тн
106.	Катионы шүүгч	-	Ky-2-8 Na	Гост 20301-73	100тн
107.	Керосин, escaid 110	-	Kerosene, ESCAID 110	64742-47-8	1000тн
108.	Кобальтын сульфат	$CoSO_4 \cdot x H_2O$	Cobalt (II) sulfate	10026-24-1	50тн
109.	Хлорын хүчил	$HClO_4$	Perchloric acid	7601-90-3	500тн

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Агуулахын барилга байгууламж нь төвийн нэгдсэн шугам сүлжээнд холбогдсон учир гадна агаарын чанарт шууд сөрөг нөлөөлөл үүсэхгүй.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу 2023 оны 6 сарын 19, 10 дугаар сарын 20-ны өдрүүдэд агуулахын орчим агаарын чанарын шинжилгээг гүйцэтгүүлсэн бөгөөд дээрх шинжилгээгээр стандарт нормоос давсан үзүүлэлт тодорхойлогдоогүй.

2.2. Усны зохистой хэрэглээ ба нөөц баялгийг хамгаалах

Тус төслийн хүрээнд усны хэрэглээ нь зөвхөн ажилчдын ахуйн болон ундны усны хэрэглээ байдаг.

Ажилчдын унд ахуйд ашиглах усыг зөөврийн цэвэр усаар хангадаг. Харин ахуйн хэрэглээнээс гарах шингэн хаягдлыг төвийн нэгдсэн бохирын сүлжээгээр дамжуулан зайлуулдаг.

2.3. Хөрс, ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арилгах, арга хэмжээ

Агуулахад хадгалагдах химийн бодис тус бүрийн аюулгүй ажиллагааны дүрэм, хор аюулын лавлах мэдээлэл, анхаарулах тэмдгийг галын болон гамшиг, ослын үед ажиллах төлөвлөгөөг химийн бодис асгарч алдагдах тохиолдолд саармагжуулах, хөрс, ургамлан бүрхэвчийг нөхөн сэргээх аргачилсан зааврын хамт боловсруулж, ажиллагсдад танилцуулан, мэдээллийн самбарт байршуулсан.

Хог хаягдлыг ангилан ялгаж, цуглуулж зайлуулах хогийн цэгүүдийг байршуулсан.

2.4. Орчны тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөгөөний биелэлт

Түрээсийн агуулахад химийн бодис хадгалдаг тул өмчлөгч байгуулагатай харилцан тохиролцож амжаагүй тул энэ жилийн ногоон байгууламжийн ажил гүйцэтгэгдээгүй.

2.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Химийн бодисын агуулахын барилга байгууламжийн ойролцоо буюу эдэлбэр газарт түүх соёлын дурсгалт зүйлс болон археологи, палеонтологийн олдвортой газар байхгүй. Иймд энэхүү төслийн үйл ажиллагаанаас түүх соёлын дурсгалт зүйлс болон археологи, палеонтологийн олдворт ямар нэгэн байдлаар сөрөг нөлөө үзүүлэхгүй юм.

2.6. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Агуулахад хадгалагдах химийн бодис бүхий сав баглаа боодлыг аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг, битүүмж бүхий хогийн саванд цуглуулж бэлтгэн, хог хаягдлыг устагах, тээвэрлэх үйл ажиллагаа явуулж буй гэрээт компанид нийлүүлэхээр бэлтгэл ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Химийн бодис агуулсан хуванцар болон бусад сав, баглаа боодол зэрэг аюултай хог хаягдлыг Цэцүүх Трейд ХХК-д гэрээний дагуу нийлүүлж дахин боловсруулах үйлдвэрт хүргүүлдэг.

ГУРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсанаар орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчны хяналт шинжилгээг 2023 оны 6-р сарын 19, 10 дугаар сарын 20-ны өдрүүдэд тус тус хийлгэсэн байна.

3.1. Агаарын чанарын хяналт шинжилгээ

3.1.1. Агаарын чанарын шинжилгээг гүйцэтгэх арга зүй

Агаарын чанарын шинжилгээг ЦУОШГ-ын харьяа Байгаль орчин хэмжилзүйн төв лабораториор гүйцэтгүүлсэн бөгөөд агаар дахь хольцын агууламжийг сонгомол дэвтээгч уусмалаар цэнэглэсэн шингээгч гуурсанд агаарыг соруулж аван азотын давхар исэл (NO₂), хүхэрлэг хий (SO₂)-г өнгөний эрчимшлийн буюу фотакалометрийн аргаар MNS 17.2.5.12:88, MNS 17.2.5.11:88 стандартын дагуу тус тус тодорхойлсон бол агаар дахь тоосны агууламжийг Dustruck 8520, дуу чимээг мөн адил зөөврийн автомат багажаар ISO 9001:2000 стандартын дагуу тодорхойлсон.

Агаар бохирдуулагч бодисуудын шинж чанар, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг дараах байдлаар тайлбарласан байдаг. Үүнд:

– Хүхэрлэг хий- SO₂

Өнгөгүй, үнэргүй хий. Түлшин дэх нүүрстөрөгч бүрэн шатаагүй үед үүсдэг. Нүүрстөрөгчийн дутуу исэл уушгиар дамжиж, цусны урсгалд орж, эсэд хүчилтөрөгчийг зөөвөрлөдөг гемоглобинтой нэгдэн “Карбоксигемоглобин” гэдэг нэгдэл үүсгэдэг. Иймээс хүний бие махбоди, эдэд очих хүчилтөрөгчийн хэмжээг багасгадаг. Зүрх судасны өвчтэй хүмүүс, тухайлбал зүрхний бах өвчтэй хүмүүс хамгийн их эрсдэлтэй бөгөөд биеийн хүчний ажил хийж байгаа үед нүүрстөрөгчийн дутуу ислийн нөлөөлөлд өртвөл цээжээр өвдөх болон зүрх судасны талаас бусад шинж тэмдгүүд илэрдэг. Зүрх судас, амьсгалын замын архаг хууч өвчтэй (зүрхний титэм судасны өвчтэй, цус багадалттай, уушигны архаг бөглөрөө өвчтэй) хүмүүс, нярай хүүхдүүд нүүрстөрөгчийн дутуу исэлд илүү өртөмтгий байдаг.

– Азотын давхар исэл NO₂

Өнгөгүй, үнэргүй хий бөгөөд агаар мандалд бор шаргал өнгөтэй болдог. Азотын давхар исэл нь уушгины эдийг цочроох ба амьсгалын замын халдварт өртөмтгий байдлыг нэмэгдүүлдэг. Азотын давхар исэл нь амьсгалын замын өвчний тохиолдлыг ихэсгэх, гуурсан хоолойн багтраа болон үрэвсэлтэй хүний мэдрэгшлийг нэмэгдүүлэх, уушгины хамгаалах механизмыг бууруулах, зүрх судасны архаг өвчнийг сэдрээх нөлөөтэй. Зүрх судасны, уушгины архаг өвчтэй хүмүүс, түүнчлэн хүүхдүүд, өндөр настнууд архаг нөлөөнд өртөмтгий байдаг.

– Тоосонцор

Агаарт хатуу, шингэн төлөв байдалтай оршдог. 10 микрометрээс бага хэмжээтэй тоосны богино (1-24 цаг) ба урт хугацааны (хэдэн жилийн) нөлөөлөл нь уушги, зүрхний өвчлөл, нас баралтын нэг хүчин зүйл болдог.

Зүрхний эсвэл уушгины өвчтэй хүмүүс, тухайлбал зүрхний архаг өвчтэй хүн, титэм судасны өвчтэй, гуурсан хоолойн багтраа өвчтэй хүн, өндөр настнууд (уушгины эсвэл зүрхний өвчингүй байж болно) тоосонд мэдрэмтгий байдаг. Зүрхний өвчтэй хүн тоосны нөлөөнд өртсөнөөс цээжээр хөндүүрлэх, чичрэх, амьсгал давхцах, сульдах, зүрхний хэмнэл алдагдах зэрэг шинж тэмдгүүд илэрдэг.


Тоос нь амьсгалын замын халдварт өвчний өртөмтгий байдлыг ихэсгэх бөгөөд амьсгалын замын архаг өвчнийг сэдрээх нөлөөтэй.

Баянгол дүүргийн 20-р хороонд байрлах агуулахын байр орчмоос агаар бохирдуулагч үндсэн хий болох азот, хүхэрлэг хий болон тоосонцрын дээжийг соруулан авч орчны нөлөөллийг үнэлэв.

Хүснэгт 2. Агаарын чанарын шинилгээний дүн


№	Сорьц авсан цэг	Сорьц авсан огноо	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м ³	Азотын давхар исэл мг/м ³	Нийт тоос /TSP/ мг/м ³	Дуу чимээ /ДБА/
1	Агуулах орчмоос	2020.06.15	10:30	0.015	0.018	0.061	50
2		2020.09.15	13:45	0.018	0.016	0.059	52
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016				0.45	0.2	0.5	60

Зураг 5. Агаар дахь хүхэрлэг хийн агууламж




Үйлдвэрийн дотоод орчинд хүхэрлэг хийн агууламж 15-18 мкг/м³ агууламжтай тодорхойлогдсон бөгөөд энэ нь MNS 4585:2016 агаарын чанарын стандартаас даруй 30 дахин бага байна.

Зураг 6. Агаар дахь азотын давхар ислийн агууламж



Азотын давхар ислийн хувьд 16-18 мкг/м³ агууламжтай байгаа нь стандарт хүлцэх хэмжээнээс 12 дахин бага байна.


Зураг 7. Агаар дахь нийт тоосонцрын агууламж



Нийт тоосонцрын агууламжийн хувьд агаар дахь 30 минутын дундаж стандарт хүлцэх хэмжээнээс 8 дахин бага байна.

Харин агаар дахь физик бохирдлын зэргийг тодорхойлох дуу чимээний бохирдлын зэргийг тодорхойлох шинжилгээний дүнгээр стандарт хүлцэх хэмжээнээс давсан үзүүлэлт тодорхойлогдоогүй байна (Зураг 8).

Зураг 8. Дуу шуугианы норм



3.2. Хөрсний чанарын хяналт шинжилгээ

Орчны хяналт шинжилгээний мониторингийн ажлын хүрээнд хөрсний бохирдлын шинж чанарыг тодорхойлохын тулд үйлдвэрийн талбайн хэсгээс дээж сонгон авч Инженер геодези ХХК-д шинжлүүлсэн.

Хөрсний бохирдлын зэргийн шинжилгээг үйлдвэрийн талбайд 2023 оны 6 дугаар сарын 19, 10 дугаар сарын 20-ны өдрүүдэд тус тус гүйцэтгэн хөрсний өнгөн давхарга дахь хүнд металлын зэргийг тодорхойлоход, үр дүн нь дараах байдлаар илэрхийлэгдэж байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Хөрсний чанарын шинжилгээний дүн

№	Дээж авсан огноо	Хүнд металл мг/кг					
		Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/
1	2023.06.19	22.0	ND	17.2	11.4	50.7	ND
2	2023.10.20	21.7	ND	16.4	10.7	51.3	ND
Хүлцэх агууламж /MNS 5850:2019/		150,0	3,0	100,0	100,0	300,0	150,0
Хортой агууламж /MNS 5850:2019/		1000,0	10,0	500,0	500,0	600,0	400,0
Аюултай агууламж /MNS 5850:2019/		1800,0	20,0	1200,0	1000,0	1000,0	1500,0

Зураг 9. Хөрсний дээж




Хүснэгт 4. Дээж авсан цэг


Уртраг	Өргөрөг
106.794354	47.899497

Хөрсний шинжилгээний дээж авахад мөрдлөг болгосон стандарт
MNS 3298:1990
ISO 15799:2003

Зураг 10. Хар тугалга, зэсийн агууламж



Зураг 11. Зэс, цайрын агууламж



Дээрх шинжилгээний дүнгүүдээс харахад тус үйлдвэрийн орчим хөрсний хүнд металлын агууламж MNS 5850:2019 стандартаас давсан үзүүлэлт тодорхойлогдоогүй хөрс цэвэр байна.

ДӨРӨВ. БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

4.1. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт


Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан химийн бодисын эрсдлийг бууруулах ажлын хүрээнд агуулахад аюулгүй ажиллагааны дүрэм, химийн бодис тус бүрийн хор аюулын лавлах, аюулын тэмдгийг байршуулж ажилчдад химийн бодистой ажиллах сургалтыг зохион байгуулсан байна.

Мөн орчны тохижилт, хөл газрын ургамлыг хадах, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийг хангах ажлуудыг ажилчид болон удирдлагын дотоод санхүүгийн нөөц бололцоог ашиглан гүйцэтгэсэн болно.

4.2. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны засаг дарга, хорооны хэсгийн ахлагч, иргэдэд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хийсэн ажлаа танилцуулж, ажиллалаа.

ХАВСРАЛТ



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt1@gmail.com



СОРИЛЫН ДҮН

Дугаар он/№	: 2023/A-116
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “ИмпериаЛ Партнерс” ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал	: Б. Батхишиг агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл	: 1 агаар, 1 дуу чимээ
Сорьц авсан огноо	: 2023.06.19
Сорьцын тодорхойлолт	: Баянгол дүүрэг, 20-р хороо, агуулах
Шинжилгээний аргын стандарт	: MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021, MNS 5002:2000, САЗ А07-2016
Шинжилсэн огноо	: 2023.06.21
Хуудасны тоо	: 1/1
Үр дүн:	

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл	Нийт тоос /TSP/	Дуу чимээ
					мг/м ³		ДБА
1	Эзэмшлийн талбай	VI/19	16:30	0.015	0.018	0.061	50
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер

Хянаж баталгаажуулсан:

Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга




Д. Түмэндэлгэр

Б. Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.

Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt1@gmail.com



СОРИЛЫН ДҮН

Дугаар он/№	: 2023/A-237
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “ИмпериаЛ Партнерс” ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал	: Б. Батхишиг агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл	: 1 агаар, 1 дуу чимээ
Сорьц авсан огноо	: 2023.10.20
Сорьцын тодорхойлолт	: Баянгол дүүрэг, 20-р хороо, агуулах
Шинжилгээний аргын стандарт	: MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021, MNS 5002:2000, САЗ А07-2016
Шинжилсэн огноо	: 2023.10.23
Хуудасны тоо	: 1/1
Үр дүн:	

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл	Нийт тоос /TSP/	Дуу чимээ
							ДБА
1	Эзэмшлийн талбай	X/20	17:20	0.018	0.016	0.059	52
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер

Хянаж баталгаажуулсан:
Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга




Д. Түмэндэлгэр

Б. Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.

Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй



**ХӨРС СУДЛАЛЫН
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**



ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК

Утас/Факс 77278899, 77288899

Email: soil_lab@geo-mongol.mn

Дугаар:23/1205

Дээж авсан огноо: 2023 он 06 сарын 19

Шинжилгээ хийсэн огноо: 2023 оны 06 сарын 20-21

Дээж авсан газрын нэр: Улаанбаатар хот, БГД, 20-р хороо, “Империл Партнерс” ХХК

Координат:-

НДТ:-

Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “Эко цогц шийдэл” ХХК

Харилцах утас:

Хөрсний хүнд металл

№	Лаб.№	Дээжийн нэр	Гүн, см	Хүнд металл мг/кг					
				Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/
1	23/1205	Хөрс-1	-	22.0	ND	17.2	11.4	50.7	ND
Хулцэх агууламж /MNS 5850:2019/				150,0	3,0	100,0	100,0	300,0	150,0
Хортой агууламж /MNS 5850:2019/				1000,0	10,0	500,0	500,0	600,0	400,0
Аюултай агууламж /MNS 5850:2019/				1800,0	20,0	1200,0	1000,0	1000,0	1500,0
Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт				/MNS 5850:2019/					

*ND-not detect

Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.

Шинжилгээ хийсэн арга стандарт:

(MNS ISO 11466:2007)

Лабораторын эрхлэгч:

Л. Цагаандархи /MS,c/

Задлан шинжээч:

Х. Жаргалмаа

